

2019 Asia Urban
Lighting Workshop

2019 아시아도시조명워크숍

주최 서울특별시 LUCI

“ГЭРЭЛТҮҮЛЭГТЭЙ, АЮУЛГҮЙ ЧОЙБАЛСАН ХОТ” ТӨСӨЛ

МОНГОЛ УЛС, ДОРНОД АЙМАГ
ЧОЙБАЛСАН ХОТ

ИЛТГЭГЧ: ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГЧ О.ПҮРЭВ-ОЧИР

Дорнод аймгийн төв Зүүн бүсийн хөгжлийн тулгуур төв Чойбалсан хот нийслэл Улаанбаатар хотоос зүүн тийш 655 км-д оршдог, 28,3 мянган га талбай бүхий нутагтай.

Чойбалсан хот нь 13.5 мянган өрхийн 47.1 мянган хүн амтай. Нийт хүн амын 36.9 хувийг 18 хүртэлх насны хүүхэд, 11.6 хувийг 55-аас дээш насны иргэд эзэлдэг.

Чойбалсан хотын хэмжээнд тохилог орон сууц 108 байна. Орон сууцны хангамжийн хувьд нийт өрхийн 4782 нь тохилог орон сууцанд, 4320 нь сууцны тусдаа байшинд, 944 нь нийтийн байранд, 2743 нь гэрт, 706 нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Нийт хүн амын 35,4 хувь нь дулаан, цахилгааны төвлөрсөн системд холбогдсон тохилог орон сууцанд амьдардаг.

Ерөнхий боловсролын төрийн болон хувийн хэвшлийн 12 сургуульд 10547 суралцагч, 23 цэцэрлэгт 4430 хүүхэд боловсрол эзэмшиж байна.

“ГЭРЭЛТҮҮЛЭГТЭЙ, АЮУЛГҮЙ ЧОЙБАЛСАН ХОТ” ТӨСӨЛ

Чойбалсан хотын Захирагчийн санаачилгаар “Гэрэлтүүлэгтэй, аюулгүй Чойбалсан хот” төслийг 2017-2020 онуудад хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төслийг 3 чиглэлээр төлөвлөн ажиллаж байна.

I. Чойбалсан хотын авто замуудыг бүрэн гэрэлтүүлэгтэй болгох

II. Чойбалсан хотын орон сууцны байруудыг бүрэн гэрэлтүүлэгтэй болгох

III. Хотын гэр хорооллуудыг бүрэн гэрэлтүүлэгтэй болгох


I. ЧОЙБАЛСАН ХОТЫН АВТО ЗАМЫГ БҮРЭН ГЭРЭЛТҮҮЛЭГТЭЙ БОЛГОХ

Сумын төсвийн хөрөнгө оруулалт болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд Чойбалсан, Хэрлэн, Зангиат, Ялалт, Хүрээ, Дамдинсүрэнгийн гудамжны 11.1 км автомашины болон явган хүний замын гэрэлтүүлгийг бүрэн шинэчилсэн.

Мөн 2018 онд Ламзавын, Уурхайн, Дамдинсүрэнгийн, Содномдаржаагийн гудамжны 11.5 км автомашины болон явган хүний замын гэрэлтүүлгийг эрчим хүчинд хэмнэлттэй лед гэрлээр шинэчлэн сольсон.

2019 онд Хан-Уул, Агын гудамжны 6.3 км автомашины болон явган хүний замын гэрэлтүүлгийг шинээр хийх байна.

2020 онд 10.8 км авто замын гэрэлтүүлгийг шинэчилснээр Чойбалсан хотын авто замыг эрчим хүчинд хэмнэлттэй, тусгал сайтай гэрлээр солих, шинээр тавих ажил дуусна.



II. ЧОЙБАЛСАН ХОТЫН ОРОН СУУЦНЫ БАЙРУУДЫГ ГЭРЭЛТҮҮЛЭГТЭЙ БОЛГОХ

Чойбалсан хотын орон сууцны байрууд, төсвийн байгууллагууд болон бусад барилгуудыг гэрэлтүүлж, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, мөн аюулгүй орчин бүрдүүлэх ажлын хүрээнд 2017, 2018 онуудад Чойбалсан хотын орон сууцны 29 барилга, төрийн болон орон нутгийн өмчийн 47 байгууллагын барилгуудыг бүрэн гэрэлтүүлэгтэй болгосон.

2019 онд орон сууцны 57 барилга, төрийн болон орон нутгийн өмчийн 19 барилга байгууламжийг гэрэлтүүлэхээр төлөвлөснөөс ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.

2020 онд орон сууцны 22 байрыг гэрэлтүүлснээр Чойбалсан хотын бүх орон сууцыг бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.



III. ЧОЙБАЛСАН ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ БҮРЭН ГЭРЭЛТҮҮЛЭГТЭЙ БОЛГОХ



Төслийн 3 дугаар чиглэлийн хүрээнд 2017, 2018 онуудад Чойбалсан хотын гэр хорооллын 18 эгнээ, 10 цэгт 180 ширхэг гэрэлтүүлгийг хийж гүйцэтгэлээ.

2019 онд гэр хорооллын 8 байршилд 420 гэрэлтүүлэгийг шинээр суурилуулах ажил явагдаж байна.

2020 онд үлдсэн 4 байршилд 700 орчим гэрэлтүүлгийг шинээр хийснээр гэр хорооллыг бүрэн гэрэлтүүлж дуусна.



“ГЭРЭЛТҮҮЛЭГТЭЙ, ЧОЙБАЛСАН
АЮУЛГҮЙ ХОТ” ТӨСӨЛ-д
зарцуулсан хөрөнгө оруулалт



НАЙРАМДАЛ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН

©BAYASAA









©BAYASAA







©BAYASAA



©BAYASAA



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА